



**INBÁZE**  
KOMUNITNÍ CENTRUM PRO MIGRANTY A ČESKOU VEREJNOST

Legerova 50, Praha 2, 120 00  
Tel.: +420 224 941 415  
GSM: +420 739 578 343  
E-mail: info@inbaze.cz  
www.inbaze.cz

**Бидэнд хандаарай – бид танд мэргэжлийн, үнэ төлбөргүй зөвлөнө!**

**ЧУ-д оршин суух зөвшөөрлийн  
өргөдлийг хэрхэн зөв өгөх вэ?**

**ЧУ-ын ДХЯ-ны гадаад иргэдийн  
оршин суух асуудлыг хариуцсан  
хэлтэс хэрхэн ажилладаг тухай**

**ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

InBáze 2012



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY

Прага дах Гадаад иргэдийн оршин суух асуудлыг хариуцсан хэлтэс дээрхи Inbáze-ийн зөвлөгөө өгөх I, II төсөл нь гадаадуудын цагаачлалыг дэмжих тэтгэлэгийн хүрээнд БНЧУ-Дотоод хэргийн яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн сууршуулах албанаас санхүүжиж буй болно.

Энэхүү нийтлэлээс БНЧУ-д оршин суух зөвшөөрлийн өргөдлөө хэрхэн хандах, ямар байдлаар захиргааны байгууллагатай харилцах, яаж зөв мэдээлэл олж авах зэрэг үндсэн мэдээллийг олж мэднэ.

## ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

**Захирагааны байгууллага/шийдвэр гаргагч байгууллага/ БНЧУ-ын ДХЯ Správní orgán/rozhodující orgán/MV ČR** – таны өргөдөлд шийдвэр гаргадаг байгууллага

**Захирагааны шийдвэрлэлт /Správní řízení/** – таны ямар нэг зорилгоор өгсөн өргөдөлд шийдвэр гаргах байдал

**Итгэмжлэл /Plná moc/** – итгэмжлэгч өөр хэн нэгэн этгээдэд албан байгууллага дээр өөрийгөө төлөөлүүлэх эрхийг олгож буй байдал (жнь: оршин суух зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх / өргөдөл өгөх / дутуу материал өгөх гэх мэт).

**Итгэмжлэгч /Zmocnitel/** – өөрийгөө төлөөлүүлэн өөр нэг этгээдэд итгэмжлэл өгч буй этгээд

**Итгэмжлэн төлөөлж буй этгээд /Zmocněnec/** – таныг төлөөлж буй этгээд

**Дээд зэргийн хуулийн хүчин төгөлдөр болгож баталгаажуулах / Superlegalizace/** – Тухайн бичиг баримт эрх бүхий албан хаагч/ байгууллагаар олгогдсон буюу батлагдсан, мөн энэ албан бичгэн дээрх гарын үсэг, албаны тамга зэргийн үнэн зөвийг баталгаажуулж байна гэдгийг тодорхойлно. Хэрвээ танай улс Гадаадын бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг хүчингүй болгосон тухай гэрээ байхгүй бол баталгаажуулалтыг апостилны байгууллага хийж болно

**Apostila** – тухайн бичиг баримтыг гадаадад хэрэглэх зорилгоор үнэн зөвийг баталгаажуулж хийж буй албан тодорхойлолт хавсралт.

**Өргөдөлд дутуу материал /Vady žádosti/** – хавсралтад байх ёстой баримт бичгээс дутсан тохиолдолд заавал бүрдүүлэх шаардлагатай

**Өргөдлийн шийдвэрлэлтийг түр зогсоох /Přerušeni řízení/** – захирагааны байгууллагын өргөдлийн шийдвэрлэгдэж буй хугацааг зогсоох шийдвэр, дутуу материалыг бүрдүүлж өгөх (эсвэл албан байгууллагын илэрүүлэлтээр) өргөдөл шийдвэрлэх явц үргэлжилнэ

**Өргөдлийн шийдвэрлэлтийг зогсоосон тухай тогтоол /Usnesení o zastavení řízení/** – Өргөдөлд илэрсэн дутагдлыг цаг хугацаанд нь бүрдүүлж засаагүй тохиолдолд эсвэл хоцорч өгсөн тохиолдолд таны өргөдлийг зогсоосон тухай тогтоол

**Өргөдлийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр /Rozhodnutí o zamítnutí žádosti/** – хуулинд заасан нөхцөл шаардлагыг хангаагүйгээс захирагааны байгууллага ЧУ дах оршин суух зөвшөөрлийг хэрэгсэхгүй болгосон тухай шийдвэр

**Давж заалдах хуулийн хугацаа /Právní moc/** – шийдвэр / тогтоолд бичигдсэн байх ба өөрчлөх боломжгүй байдаг

**Давж заалдах гомдол шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлнэ / Odkladný účinek odvolání/** – заасан хугацаанд давж заалдах өргөдөл гаргасан бол шийдвэр хүчин төгөлдөр болохгүй, өөрөөр хэлбэл шийдвэрт өөрчлөлт гарах магадлалтай

**Түр хугацааны виз /Překlenovací štítek/** – түр хугацааны виз хуульд заасан хугацаанд (оршин суух зөвшөөрөл дуусахаас өмнө хамгийн эртдээ 90 хамгийн оройдоо 14 хонгийн өмнө) оршин суух зөвшөөрлөө сунгуулах өргөдөл өгснөөс хойш шийдвэр гарах хүртэл хугацаанд хүсэж болно. Энэ нь таны өмнөх оршин суух зөвшөөрөлтэй ижил статустай

**Гадаад иргэдийн оршин суух тухай хууль /Zákon o robytu cizinců/** – гадаад иргэдийн оршин суух тухай гол эрх зүйн хэм хэмжээ. Бүх өөрчлөлтийг эндээс харж болно:

<http://www.mvcr.cz/clanek/sluzby-pro-verejnost-informace-pro-cizince-informace-pro-cizince.aspx>

## ХЭН ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТ ӨГЧ БОЛОХ ВЭ

Өргөдлийг 15 - аас дээш насны хуулийн этгээд өгч болно.

**!** 15 хүртэлх насанд хүрээгүй хүүхдийг хууль ёсны төлөөлөгч төлөөлнө (эцэг эх, асран хамгаалагч). 15 настай хүүхэд заавал өөрийн биер өргөдлөө өгнө!

### ӨӨРИЙН БИЕЭР БАЙХ

Дараах тохиолдлуудад заавал ӨӨРИЙН БИЕЭР ирэх хэрэгтэй

- Удаан хугацааны болон байнгийн оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгөхдөө
- Хурууны хээ болон цээж зураг авах үеэр
- Оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ авахдаа / 6 хуртлэх насны хүүхдийн үнэмлэхийг эцэг эх нь авч болно /

### ИТГЭМЖЛЭН ТӨЛӨӨЛӨХ

Намайг хэн нэгэн төлөөлж болох уу?

- ТИЙМ БОЛНО.

Дараах тохиолдлуудад:

- оршин суух зөвшөөрлийг сунгуулах
- өргөдөлд дутуу бичиг баримтыг нөхөн бүрдүүлэх (жнь: ДУТУУ МАТЕРИАЛ)
- хавтаст баримтанд орсон материалтай танилцах, хуулбарлах, фото зургийг нь авах
- өргөдлийн байдал шийдэлтийн талаар мэдээлэл авах
- давж заалдах өргөдөл гаргах
- оршин суух зөвшөөрлийн тухай тодорхойлолт авах өргөдөл гаргах

### ХЭН НАМАЙГ ТӨЛӨӨЛЖ БОЛОХ ВЭ

18 нас хүрсэн хуулийн хариуцлага хүлээх чадвартай этгээд бүр, мөн хуулийн байгууллага (өмгөөлөгч байх албагүй).

Төлөөлөх үед тухайн төлөөлж буй этгээдтэй ИТГЭМЖЛЭЛ хийх хэрэгтэй.

### ИТГЭМЖЛЭЛ

- **Итгэмжлэл, тодорхой нэг төрлийн хуулийн үйл явц**

Ийм итгэмжлэл нь зөвхөн тодорхой үйл явц, даалгаврыг гүйцэтгэхэд итгэмжлэгдсэн байна. Итгэмжлэл бүр нотариатаар батлуулсан байх албагүй, итгэмжлэл хийгч гарын үсгээ зурахад хангалттай (итгэмжлэгч).

Жишээ нь.:

- итгэмжлэл – зөвхөн өргөдөл өгөхөд
- итгэмжлэл – өргөдөлд дутуу бичиг баримтыг нөхөн бүрдүүлж өгөхөд
- итгэмжлэл – хавтаст баримтанд орсон материалтай танилцах, хуулбарлах, зурагыг авахад
- итгэмжлэл – давж заалдах өргөдөл гаргахад

**Бид танд энэ төрлийн итгэмжлэлийг хийхийг зөвлөж байна!**

Үүний хүчин төгөлдөр байдал тухайн даалгаврын гүйцэтгэлээр дуусгавар болно.

- **Өргөдлийг шийдвэрлэх ажиллагааны туршид хүчинтэй байх итгэмжлэл**

Ийм итгэмжлэл нь оршин суух зөвшөөрлийн өргөдлийг шийдвэрлэх явцын туршид бүх төрлийн үйл явц даалгаврыг гүйцэтгэх эрхийг итгэмжлүүлэгчид олгодог. Үүнийг тодорхой хязгаартай хугацаагаар хийхийг зөвлөж байна.

**!** Энэ тохиолдолд захиргааны байгууллага итгэмжлүүлэгчийн нэр дээр таны бүх бичиг баримт, захиаг явуулж болно.

Үүний хүчин төгөлдөр байдлыг итгэмжлүүлэгчийн оролцоогүйгээр өөрөөр хэлбэл нэг талын хүсэлтээр дуусгавар болгож болно! Энэ тухай ЧУ-ын ДХЯ мөн итгэмжлүүлэгчид албан захиагаар мэдэгдээрэй.

**!** Итгэмжлэгдсэн этгээд итгэмжлэл цуцлагдсан тухайгаа мэдээгүй байвал итгэмжлэл хүчинтэй байна.

## АЛБАН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ

### ДҮРЭМ

- **Албан ёсны баримт гэж зөвхөн бичгэн, баримт мэдээллийг тооцдог**

**!** Захирагааны байгууллага танд утсаар эсвэл аман хэлбэрээр мэдэгдсэн мэдээлэл албан ёсны байх албагүй!

- **Албаны ярилцах хэл чех хэл**

Албаны ярилцах хэл чех хэл Бүх шаардлагатай албан ёсны бичиг баримтууд чех хэлээр байна эсвэл чех хэл рүү албан ёсоор орчуулсан байна. Гадаад улсын бичиг баримтуудад хуулийн нэмэлт бичиг хавсаргана, (дээд зэргийн хуулийн хүчин төгөлдөр болгох / superlegalizace/ эсвэл Апостилле /apostila/).

Жишээ нь: өөрийн эх орноосоо авчирсан төрсний гэрчилгээтэй бол заавал албан ёсны орчуулагчаар чех хэлрүү орчуулуулсан байх ёстой. Орчуулагч дээр орчуулагчийн албан ёсны тамга байна.

**!** Хэрвээ танай улс ЧУ-тай Гадаадын бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг хүчингүй болгосон тухай гэрээ байхгүй бол төрсний гэрчилгээг эхлээд танай улсын төлөөлөгчийн газар баталгаажуулна эсвэл танай Гадаад зэргийн яам (дээд зэргийн хуулийн хүчин төгөлдөр болгох хавсаргалт/superlegalizace/).

• **Хэзээд өөрийн өргөдлийн дугаараа мэдэгдээрэй.**

Энэ нь албан байгууллагаас таны өргөдөлд өгч буй хувийн дугаар юм. Дугаараа андуурахаас бологоомжлоорой. Дугаар нь дараах байдлаар харагдана: **OAM-12345-1/DP-2012**. Өөрийн өргөдлийн дугаараа мэдэхгүй бол өргөдөл өгсөн гэсэн тодорхойлолтоо хүсээрэй.

• **Та өргөдлөө өгсөнөөс хойш шийдвэр гарах хүртэлх хугацаанд ажиллагааны тухай идэвхтэйгээр асууж лавлах, оролцох эрх байдаг**

- та өөрийн өргөдөл/хавтаст бичиг баримтандаа шинээр нотолгоо баримтыг хавсаргахыг санал болгох эрхтэй;
- та өөрийн хавтаст баримтанд орсон материалтай танилцах эрхтэй;
- хэрвээ таны өргөдлийн байдал хангалттай биш санагдвал шийдвэр гаргахаас өмнө таныг өөрийн биер ирж хавтаст бичиг баримтандаа ямар нэг байдлаар илэрхийлэх боломж олгосон баталгаат захиаг явуулдаг.

• **Албан байгууллагатай харилцах үед байнга өөрийн хүчин төгөлдөр хаяг, email, утсаа мэдэгдэж байх**

ЧУ ДХЯ тантай захиагаар, утсаар email-ээр харилцаж болно. Хэзээд хүчин төгөлдөр байгаа хаяг, email, утсаа мэдэгдэж байгаарай. таны, танай хүүхдүүдийн нэр шуудангийн хайрцаган дээр бичээстэй байгаа эсэх дээр анхаараарай

• **Та бичиг баримтаа шуудангаар явуулах боломжтой боллоо**

Захиргааны байгууллага таны өргөдөлд дутуу бичиг баримтыг (жнь: албан захиагаар дамжуулан) нөхөн бүрдүүлэхийг хүссэн бол та үүнийг шуудангаар явуулж болно. Хэзээд БАТАЛГААТ шуудангаар явуулаарай, баталгааны жижиг хуудсыг явуулсан нотолгоо болгож хадгалаарай. DODEJKA үйлчилгээг ашиглаж болно – энэ нь таны шууданг хүлээн авагчид хүргэсэн гэсэн бичгэн тодорхойлолтыг танд хүргэх үйлчилгээ юм.

• **Та бичиг баримтаа өөрийн биеэр авчирч өгсөн тохиолдолд баталгаа болох баримтаа шаардаж авна уу**

ЧУ-ын ДХЯ-ны хэлтэс байгууллага дээр та өөрийн биер бичиг баримтаа өгсөн бол захиргааны байгууллагаас материалаа өгсөн гэсэн тодорхойлолтыг хүсэж болно, үүнийг нямбайлан хадгалаарай. Мөн өргөдөлдөө хавсаргаж байгаа бүх бичиг баримтуудын бичгэн жагсаалт хийх боломж байдаг, энэ жагсаалтыг баталгаажуулж ЧУ-ын ДХЯ тамга дарна.

**ЧУ-ЫН ДХЯ-НЫ АЛБАН ЗАХИА**

ЧУ-ын ДХЯ албан ёсны бичиг баримтыг Чехийн шуудангийн үйлчилгээгээр дамжуулан явуулдаг.

• **Албан захианууд**

- хөх туузан зураастай дугтуй
- улаан туузан зураастай дугтуй

Хөх туузан зураастай дугтуйтай захиаг ГАРТ НЬ ХҮРГЭХ ЁСТОЙ. Шуудангийн илгээмжийн хаяг хувь хүнд бол зөвхөн тухайн хаягласан хүнд, эсвэл түүний итгэмжлэн төлөөлөгдсөн этгээд, хууль ёсны төлөөлөгч эсвэл хууль ёсны төлөөлгчийн итгэмжлүүлэгчид өгдөг: харин байгууллагын нэр дээр хаягласан байвал зөвхөн эрх бүхий этгээдэд өгнө. Тухайн этгээдийн гарт нь хүргэх боломжгүй бол захиа ЧУ-ын ДХЯ-нд буцаан явуулна.

Захиаг хүлээж авах тухай итгэмжлэл шуудан дээр баталгаажуулсан БАЙХ ЁСТОЙ.

Улаан туузан зураастай дугтуйтай захиаг ГАГЦХҮҮ ТУХАЙН ЭТГЭЭДИЙН ГАРТ НЬ ХҮРГЭХ ЁСТОЙ. Хэрвээ боломжгүй бол илгээмж ЧУ-ын ДХЯ-нд буцаан явуулна. Энэ үйлчилгээ зөвхөн хувь хүнд зориулсан байдаг.

Энэ төрлийн илгээмжийг хүлээн авахад итгэмжлэл хийх боломжгүй.

Ерөнхий итгэмжлэл хийсэн тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх ажиллагааны турш итгэмжлэн төлөөлөгдсөн этгээдийн нэр дээр албан захиаг явуулдаг.

• **Таныг эзгүйд шуудангийн ажилтан танд захидал авчирах**

Шууданч таныг эзгүйд ирсэн тохиолдолд хайрцаганд танд захидал ирсэн тухай мэдэгдэх хуудас хийнэ. Мэдэгдэх хуудсанд шуудангийн аль салбараас захидал авах ба захидал авч болох цаад хугацааг заасан байх бөгөөд захидлыг гадаад паспорт эсвэл биометрийн үнэмлэхээ шалгуулж авна. Захидлыг 10 хоногийн дотор аваагүй тохиолдолд ЧУ-ын ДХЯ-нд буцаан явуулна.

Хэрэв та удаан хугацаагаар гадаад руу зорчих гэж байгаа бол тухайн улсад албан захидал хүлээн авах хаягийг ЧУ-ын ДХЯ-нд мэдээлэхийг зөвлөж байна.

Хуулиар заасан хугацаа өнгөрмөгц захидлыг эзэнд нь хүргүүлсэнд тооцох тул захиргааны байгууллага таны хэргийг таны оролцоогүйгээр хянан шийдвэрлэнэ.

• **Захидал хүлээн авагчын хаяг үл мэдэгдэх**

Шуудангийн хайрцаган дээр таны нэр бичигдээгүй аль эсвэл та холбогдох байгууллагад хаягаа өөрчилснөө мэдэгдээгүйгээс шалтгаалан захидал хүлээн авч чадаагүй тохиолдолд захидлыг танд нийтийн зар мэдээ хэлбэрээр хүргэнэ.

• **Нийтийн зар мэдээ**

Албан захидлыг авч болох тухай захиргааны байгууллагын анхааруулгыг тус улсын ДХЯ-ны Гадаадын иргэдийн оршин суух асуудлыг эрхэлсэн хэлтсийн мэдээллийн самбарт, ДХЯ-ны [www.mvcr.cz](http://www.mvcr.cz) веб хуудсанд тус тус байрлуулсан байдаг.

Анхааруулга мэдээллийн самбарт тавьснаас хойш 15 дах хоног дээр албан захидал хүлээн авагчид хүргэсэнд тооцно.

**ТӨЛБӨР АЛБАН ХУРААМЖ**

БНЧУ-ын Дотоод Хэргийн Яаманд төлөх бүх төлбөр албан хураамж үнийг нь заасан төлбөрийн марк хэлбэрээр төлдөг бөгөөд төлбөрийн маркийг тус улсын шуудангийн бүх салбарт худалдаалдаг.

**ТУС УЛСАД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ ГАРГАХ**

Тус улсад оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг гадаадын иргэн биечлэн гаргах буюу өөрөөр хэлбэл БНЧУ-ын ДХЯ-нд биечлэн очих ёстой.

Хүсэлтийг шуудангаар явуулсан тохиолдолд 5 хоногийн дотор ЧУ-ын ДХЯ-нд биечлэн очих үүрэгтэй. Тэгээгүй бол таны оршин суух зөвшөөрлийн асуудлаар захиргааны ажиллагаа үүсгэхгүйгээр хүсэлтийг тань буцаана.

Албан байгууллагад дараах тохиолдолд ЯМАГТ биечлэн очих шаардлагатай. Үүнд,

- удаан хугацааны ба байнгын оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргах үед,
- биометрийн өгөдөл өгөх үед,
- биометрийн үнэмлэх авах үед

Бусад тохиолдолд материалаа шуудангаар явуулах эсвэл итгэмжлэл бүхий итгэмжлүүлгч, хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан хүргүүлж болно.

Бүрдүүлэх шаардлагатай бүх материалыг иж бүрнээр нь хавсаргавал өргөдлийн шийдвэрлэх ажиллагааг түргэсгэнэ.

Өргөдлийн материалд ямар нэгэн баримт дутсан ч ямагт цаг хугацаанд нь өгөх шаардлагатай. Дутсан баримт бичгийг дараа нь нөхөн бүрдүүлж өгч болно.

**ЧУХАЛ ХУГАЦААНУУД**

• **Хүсэлт гаргах хугацаа**

Хүсэлтийг одоо байгаа оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө 90-ээс 14 хоногт багтаан гаргана.

• **Хугацаа хэтрэх**

Та өөрөөсөө үл хамаарах хүндэтгэх шалтгааны улмаас хугацаа хэтэрсэн тохиолдолд гарсан саатал арилмагц 3 хоногийн дотор хүсэлтээ гаргах үүрэгтэй.

Өргөдөлөө өгөхдөө хугацаа хэтэрүүлсэнд уучлалт гуйсан өргөдөл бичиж, өвчний акт зэрэг гарсан шалтгааныг нотолсон баримт бичгийн хамт бүрдүүлнэ (жнь: хөдөлмөрийн чадвараа алдсан бичиг).

Таны эсвэл таны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээгүй гэсэн шалтгааныг хүндэтгэх шалтгаанд тооцохгүй.

**ӨРГӨДӨЛД ХАРИУ ШИЙДВЭР ГАРГАХ ХУГАЦАА**

**ДХЯ-нд өгсөн өргөдөлд хариу өгөх гол хугацаанууд:**

60 хоног – хувиараа ажил/бизнес эрхлэх, хөдөлмөр эрхлэх, суралцах зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл болон байнгын оршин суух зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргах хугацаа

270 хоног – Чех улсын газар нутаг дээр гэр бүлтэйгээ хамтран оршин суух зорилгоор удаан хугацааны зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргах хугацаа

60 хоног – Европын Холбооны иргэний гэр бүлийн гишүүний түр болон байнгын оршин суух зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргах хугацаа

30 хоног – зорилго солихгүйгээр удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгах тухай шийдвэр гаргах хугацаа болон Европын холбооны иргэний түр оршин суух баталгаа гаргах хугацаа

Шийдвэрт хариу өгөх хугацааг БНЧУ-ын нутаг дээр өргөдөл өгсөн өдрөөс эхлэн тоолно.

Шийдвэр гаргах хугацааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг БНЧУ-ын Дотоод Хэргийн Яамны веб хуудаснаас үзнэ үү.

<http://www.mvcr.cz/clanek/obcane-tretich-zemi-prubeh-rizeni-thuty-a-pocitani-casu.aspx>

## **ХУГАЦАА ТООЛОХ**

Хугацаа тоолоход тухайн баримт бичгийг хүргүүлсэн өдөр нь чухал байдаг. Учир нь хугацаа баримт бичгийг хүргүүлсэн өдрийн дараах өдрөөс эхлэн тоолно. Өөрөөр хэлбэл баримт бичгийг заасан хугацааны сүүлийн өдөр гэхэд захиргааны байгууллагад биечлэн хүргүүлсэн байх аль эсвэл шуудангаар явуулсан байх хэрэгтэй. Баримт бичгийг заасан хугацааны сүүлийн өдөр шууданд өгч явуулбал хугацаа хэтрээгүй гэж үзнэ.

## **АЖИЛЛАГААНЫ ЖУРМААС**

### **БАРИМТ БИЧИГ МАТЕРИАЛ ДУТАХ**

БНЧУ-ын ДХЯ таны хүсэлтийн хамт бүрдүүлсэн материал дутагдалтай гэж үзсэн тохиолдолд таны хаягаар дутсан материалын нөхөн бүрдүүлэхийг хүссэн захидал явуулна. Захидалд материалыг нөхөн бүрдүүлэх хугацаа заахын зэрэгцээ шийдвэрлэлтийг түр завсардуулна. Захидалд заасан хугацаа өнгөрмөгц шийдвэрлэлтийг цааш үргэлжлүүлэх болно.

### **ШИЙДВЭР ГАРГАХЫН ӨМНӨ МАТЕРИАЛТАЙ ТАНИЛЦАХААР ЗАРЛАН ДУУДАХ**

ЧУ-ын ДХЯ-аас таныг шийдвэр гаргахаас өмнө уг асуудалд холбогдох материалтай танилцахаар дуудах эрхтэй. Яамнаас хүсэлтийг ямар нэгэн дутагдалтай гэж үзсэн тохиолдолд ийнхүү дууддаг.

**Заасан хугацаанд дутсан материал гүйцээж явуулах боломжгүй бол үндэслэл тайлбар бүхий хугацааг сунгах тухай өргөдөл бичгээр гаргаж болно.**

### **ХАВТАСТ БАРИМТАНД ОРСОН МАТЕРИАЛТАЙ ТАНИЛЦАХ**

Та ажиллагааны явцад танай асуудалд холбогдох хавтаст баримтанд орсон материалтай танилцаж, эдгээр материалаас иш татаж, хуулбар хийх эрхтэй. Тэгэхийн тулд та хавтаст баримтанд орсон материалтай танилцах хүсэлтийг гаргах шаардлагатай. ЧУ-ын ДХЯ-аас хүсэлт гаргасан этгээдтэй холбоо барьж цагийг мэдэгддэг тул хүсэлтэд өөрийн утасны дугаараа бичих нь чухал. Материалтай танилцсаны дараа хавтаст баримтанд орсон материалтай танилцсан тухай тэмдэглэлд гарын үсэг зурна.

**Бүх материалын зургийг гэрэл зургийн аппаратаар авч болно.**

### **ЗАРЛАН ДУУДАХ ХУУДАС**

Өргөдлийг шийдвэрлэх ажиллагааны явцад таныг ЧУ-ын ДХЯ-аас мэдүүлэг өгөхөөр зарлан дуудаж магадгүй. Зарлан дуудах хуудсанд заасны дагуу ДХЯ-ны харъяа гадаад иргэдийг хариуцсан хэлтэс дээр очоогүй тохиолдолд торгууль оноогдох эсвэл цагдаагийн ажилтан нараар албадан ирүүлэх хүртэл арга хэмжээ авна.

**Хэрэв та заасан хугацаанд очиж чадахгүй бол ЧУ-ын ДХЯ-нд утсаар ярьж очих хугацааг өөрчлөх талаар тохиролцох нь зүйтэй.**

## **ӨРГӨДЛИЙН ТАЛААРХ ШИЙДВЭР**

### **ӨРГӨДЛИЙГ ТАНЬ НААШТАЙ ШИЙДВЭРЛЭСЭН**

- БНЧУ-ын ДХЯ-аас тантай утсаар холбоо барих бөгөөд таны хүсэлтийг нааштай шийдвэрлэсэн тухайгаа мэдэгдэж таныг заавал өөрийн биеэр биометрийн өгөгдөл болон гарынхаа үсгийн загвараа холбогдох байгууллагад ирж өгөхийг шаардана.
- БНЧУ-ын ДХЯ-аас таны хаягаар ирүүлсэн шийдвэрийн тухай мэдэгдэлд ажиллагааны үр дүн, шийдвэрийн талаар танилцуулсан байна. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс 30 хоногийн дотор зөвшөөрөл хүлээн авч, биометрийн өгөгдлийг авахуулах хэрэгтэй.

**ЧУ-ын ДХЯ-ы веб хуудсанд байруулсан <http://www.mvcr.cz/clanek/informace-o-stavu-rizeni.aspx> шийдвэрлэлтийн байдлыг шалгах хэсгээс хүсэлтийг шийдвэрлэсэн эсэхийг шалгаж болно.**

### **Зөвшөөрлийг хүлээн авах**

Зөвшөөрлийг ДХЯ-ы харъяа салбарт ямагт биечлэн очиж гадаад паспорт, биеийн байцаалт шалгуулж авна. Зөвшөөрлийг авах хугацаа оршин суух зөвшөөрөл хүлээн авах мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс 30 хоног байна. Заасан хугацаанд зөвшөөрлөө очиж аваагүй бол ажиллагааг зогсооно.

Биометрийн өгөгдөл авсны дараа танд биометрийн үнэмлэх өгнө.

### **Биометрийн үнэмлэх хүлээн авах хугацаа**

- ЧУ-ын ДХЯ-аас танд үнэмлэх авах хугацааг утсаар мэдэгдэх бөгөөд үнэмлэхийг зөвхөн БИЕЧЛЭН очиж авна.
- та өөрөө ЧУ-ын ДХЯ- уруу утсаар ярьж цаг авна.
- БНЧУ-ын ДХЯ-аас танд цэнхэр зураастай дугтуй бүхий Биометрийн үнэмлэх хүлээн авах тухай мэдэгдэл ирүүлэх бөгөөд уг мэдэгдэлд биометрийн үнэмлэх хугацаа заасан байна.



Та биометрийн өгөгдөл авахуулсан өдрөөс эхлэн 60 хоногийн дотор ДХЯ-нд биечлэн очиж биометрийн үнэмлэхээ авах үүрэгтэй.

Жич: Байнгын оршин суух зөвшөөрөл ба эрүүл мэндийн даатгал - ЧУ-ын ДХЯ таныг шууд нийтийн эрүүл мэндийн даатгуулагчийн бүртгэлд бүртгүүлнэ. Байнгын оршин суух зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн та нийтийн эрүүл мэндийн даатгалын тухай хуульд хамрагдах тул энэ хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

### **ӨРГӨДЛИЙГ ТАНЬ ХЭРЭГССЭНГҮЙ**

#### **Өргөдлийн шийдвэрлэлтийг зогсоосон тухай тогтоол**

ЧУ-ын ДХЯ таны өргөдлийг шийдвэрлэхгүй яагаад гэвэл өргөдөл илэрсэн дутагдлыг цаг хугацаанд нь бүрдүүлээгүй тохиолдолд эсвэл хоцорч өгсөн тохиолдолд

#### **Өргөдлийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр**

ЧУ дах оршин суух зөвшөөрлийг хэрэгсэхгүй болгосон тухай шийдвэр гаргасан учир нь хуулинд заасан нөхцөл шаардлагагыг хангаагүй болно.

#### **Давж заалдах**

Татгалзсан шийдвэр гаргасан тохиолдолд шийдвэр/тогтоол авсан өдрөөс эхлэн 15 хоногийн дотор ДХЯ-ны Гадаадын иргэдийн оршин суух хэргийг хянан шийдвэрлэх асуудлыг эрхэлсэн хороонд давж заалдах эрхтэй болно. Давж заалдах өргөдөл гаргасны дараа та түр хугацааны виз олгохыг хүсч болно.

### **ЧУ-ЫН ДХЯ ШИЙДВЭРИЙГ ХУУЛИНД ЗААСАН ХУГАЦААНД ГАРГААГҮЙ**

#### **Шийдвэрлэлтийг түргэсгэх өргөдөл**

Ажиллагааг түргэсгэх өргөдлийг шийдвэр гаргаж буй холбогдох байгууллагад гаргаарай. Өргөдөлд өөрийн өргөдлийн дугаарыг бичээрэй.

#### **Захиргааны байгууллагын хариу шийдвэр гаргах хугацаа хэтэрсэнд гомдол гаргах**

Таны асуудлаарх ажиллагаа эрчимтэй явахгүй бол захиргааны байгууллагын хариу шийдвэр гаргах хугацаа хэтэрсэнд гомдол гаргаж болно.

БНЧУ-ын ДХЯ хуулиар заасан хугацаандаа шийдвэр гаргаагүй тохиолдолд дээд шатны байгууллага түүний эс үйлдэхүйн байдлын тухай мэдээлэл авмагц зохих арга хэмжээ авна.

Захиргааны байгууллагын хуулиар заасан хугацаандаа шийдвэр гаргаагүй эсрэг гомдлыг бичгээр үйлдэн Гадаадын иргэдийн оршин суух хэргийг хянан шийдвэрлэх асуудлыг эрхэлсэн хороонд хүргүүлэх бөгөөд тус хороо хүлээн авсан гомдлыг 30 хоногийн дотор хянан шийдвэр гаргах үүрэгтэй.

Холбоо барих хаяг:

**Komise pro rozhodování ve věcech pobytu cizinců**

nám. Hrdinů 1634/3

Poštovní schránka 155/S0

140 21 Praha 4

ID datové schránky: b78xtfa

#### **Шийдвэр гаргагч байгууллагын эс үйлдэхүйн улмаас нэхэмжлэл гаргах**

Нэхэмжлэл гаргаснаар шүүхээс захиргааны байгууллагад шийдвэр гаргахыг даалгаж болно. Нэхэмжлэлийг шийдвэр гарах байсан өдрөөс эхлэн нэг жилийн дотор гаргаж болно.

## ТАНД ЗӨВЛӨЖ БАЙНА

- Бүх зүйслийг зөв ойлгосон эсэхээ яамны ажилтанаас дахин лавлан асуухаас санаа зовох хэрэггүй.
- Чех хэлийг сайн мэдэхгүй тохиолдолд . үл ойлголцол, андууралд орохгүйн тулд орчуулагчтай хамт ирээрэй
- ДХЯ-ны харъяа зарим салбарууд дээр соёл хоорондын зуучлагч/хэлмэрч танд англи, орос, араб, монгол, вьетнам хэл рүү үнэ төлбөргүй хэлмэрчилнэ.
- Хууль, нийгмийн асуудлаар үнэ төлбөргүй, чанартай зөвлөгөөг хүргэдэг ТББ-ын үйлчилгээг ашиглаарай.
- Өөрийн асуудлаа өөрөө зохицуулахаас айх хэрэггүй, Бид танд туслана
- Өргөдлийг шийдвэрлэхэд ямар хэмжээний албан хураамж төлдөг эсэхийг асуухаас бүү санаа зовоорой
- Итгэмжлэлийг гагцхүү итгэж байгаа хүнтэйгээ хийгээрэй
- Итгэмжлэлийг зөвхөн тодорхой нэг даалгавар дээр хийгээрэй-бүх л ажиллагааны туршид биш,
- Итгэмжлэлийн нэг хувийг байнга хадгалаарай
- Ямагт итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр, хаяг, утас, емэйлыг тэмдэглээрэй

### ХЭЗЭЭ Ч ХИЙЖ БОЛОХГҮЙ ЗҮЙЛС!

- Зуучлалд төлж буй мөнгөө өргөдлийн хариу шийдвэр гарахаас өмнө хэзээ ч бүгдийг бүү өгөөрэй.
- Өөрийн паспортаа таныг төлөөлж буй этгээдэд хэзээ ч бүү өгөөрэй
- Танихгүй хүнтэй итгэмжлэл хэзээ ч бүү хийгээрэй
- Оршин суух зөвшөөрөлтэй холбоотой асуудлын шийдвэрлэлтийг хэзээ ч бүү хойш нь тавиарай.

ЧУ-д байдаг төрийн бус байгууллагууд танд хэрхэн яаж зөв, үнэ төлбөргүй өргөдлөө өгөхийг зөвлөнө! Санаа зоволтгүйгээр холбоо бариарай!

БНЧУ-ын ДХЯ-ны мэдээлэл: [pobyty@mvcr.cz](mailto:pobyty@mvcr.cz), <http://imigracniportal.cz>

## Тусламж, орчуулага гадаад иргэдийг хариуцсан салбар дээр

ЧУ-ын Дотоод хэргийн яамны Гадаад иргэдийг хариуцсан Прага-ын Kopčova, Cigánkova, Bohdalec салбарууд дээр туслалцаа зөвлөгөө дараах төрлүүдээр:

- монгол, араб, вьетнам, орос, франц болон англи хэлрүү орчуулага хийнэ
- оршин суух зөвшөөрлийн талаар анхан шатны зөвлөгөө
- анкет бөглөх, өргөдөл бичих

### Салбар Kopčova 188/32, Praha 3 – Žižkov

Хаана: 2-р давхарт, гуравдагч орны иргэдийн хэсэгт

Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв
9.00 – 17.00	9.00 – 15.00	9.00 – 14.00	9.00 – 13.00

### Салбар Cigánkova 1861/2, Praha 4 – Chodov

Хаана: 1-р давхарт, гуравдагч орны иргэдийн хэсэгт

Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв
9.00 – 14.00	9.00 – 14.00	9.00 – 15.00	9.00 – 13.00


### Салбар Nad Vršovskou horou 88/4, Praha 10 – Bohdalec


Хаана: 2-р давхарт, гуравдагч орны иргэдийн хэсэгт


Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв
9.00 – 14.00	–	9.00 – 13.00	9.00 – 13.00

Албан байгууллагатай харилцах үед хамт явж хэлмэрчлэх үйлчилгээг соёл хоорондын зуучлагч/ хэлмэрчийн цагийн боломжийг үндэслэн хүргэнэ.

### СОЁЛ ХООРОНДЫН ЗУУЧЛАГЧТАЙ ХОЛБОО БАРИХ

 732 547 886  
[rus@inbaze.cz](mailto:rus@inbaze.cz)

 732 549 586  
[arab@inbaze.cz](mailto:arab@inbaze.cz)

 608 528 806  
608 817 531  
[viet@inbaze.cz](mailto:viet@inbaze.cz)

 775 283 481  
[mon@inbaze.cz](mailto:mon@inbaze.cz)

 773 898 680  
[fr@inbaze.cz](mailto:fr@inbaze.cz)

### Төрийн бус буюу ашигийн бус байгууллага гадаад иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө өгч байна

ПРАГ ХОТ +  
ТӨВ ЧЕХ

**InBáze**  
Legerova 50, 120 00 Praha 2  
tel.: 224 941 415, 739 037 353  
732 547 886 (rus), 608 528 806 (viet)  
e-mail: [info@inbaze.cz](mailto:info@inbaze.cz)  
web: <http://inbaze.cz/>

**Poradna pro integraci (PPI)**  
Senovážná 2, 110 00 Praha 1  
tel.: 224 216 758, 224 233 034  
e-mail: [paha@p-p-i.cz](mailto:paha@p-p-i.cz)  
web: <http://p-p-i.cz/>

**Sdružení pro integraci a migraci (SIMI)**  
Senovážná 2, 110 00 Praha 1  
tel.: 224 224 379  
603 547 450, 605 253 994  
e-mail: [poradna@refug.cz](mailto:poradna@refug.cz)  
web: <http://www.migrate.com/>

**Diakonie Českobratrské církve evangelické (DČCE)**  
Belgická 22, 120 00 Praha 2  
tel.: 242 487 812  
e-mail: [ustredi@diakoniecce.cz](mailto:ustredi@diakoniecce.cz)  
web: <http://www.diakonie.cz/>

**Organizace pro pomoc uprchlíkům (OPU)**  
Kovářská 939/4, 190 00 Praha 9  
tel.: 284 683 714, 284 683 545  
e-mail: [opu@opu.cz](mailto:opu@opu.cz)  
web: <http://www.opu.cz/>

**Centrum pro integraci cizinců (CIC)**  
Kubelíkova 55, 130 00 Praha 3  
tel.: 222 360 452, 222 360 834  
e-mail: [info@cicpraha.org](mailto:info@cicpraha.org)  
web: <http://www.cicpraha.org/>

**Poradna pro migranty a uprchlíky (Arcidiézni charita Praha)**  
Pernerova 20, 186 00 Praha 8  
tel.: 224 813 418  
e-mail: [uprchlici@charita-adopce.cz](mailto:uprchlici@charita-adopce.cz)  
web: <http://praha.charita.cz/>

**Integrační centrum Praha o. p. s. (ICP)**  
Žitná 1574/51, 110 00 Praha 1  
tel.: 252 543 846, 774 736 610  
e-mail: [info@icpraha.com](mailto:info@icpraha.com)  
web: <http://icpraha.com/>

**Mezinárodní organizace pro migraci (IOM)**  
Čechova 23, 170 00 Praha 7  
tel.: 233 370 160  
e-mail: [prague@iom.int](mailto:prague@iom.int)  
web: <http://www.iom.cz/>

**Klub Hanoi**  
Libušská 319, 142 00 Praha 4  
tel.: 603 583 690, 608 338 257  
e-mail: [klubhanoi@klubhanoi.cz](mailto:klubhanoi@klubhanoi.cz)  
web: <http://klubhanoi.cz/>

**Info-dráček**  
Libušská 319, 142 00 Praha 4  
tel.: 776 457 265, 776 082 929  
e-mail: [info@info-dracek.cz](mailto:info@info-dracek.cz)  
web: <http://info-dracek.cz/>

**La Strada Česká republika**  
P. O. Box 305, 111 21 Praha 1  
SOS a infolinka: 222 71 71 71,  
800 07 77 77 (bezplatné volání)  
e-mail: [pomoc@strada.cz](mailto:pomoc@strada.cz)  
web: <http://www.strada.cz>

**META – Sdružení pro příležitosti mladých migrantů**  
Ječná 17, 120 00 Praha 2  
tel.: 222 521 446, 775 339 003  
e-mail: [info@meta-os.cz](mailto:info@meta-os.cz)  
web: <http://meta-os.cz>

**Poradna pro občanství, občanská a lidská práva (PPO)**  
Ječná 7, 120 00 Praha 2  
tel.: 270 003 281, 270 003 280  
e-mail: [poradna@poradna-prava.cz](mailto:poradna@poradna-prava.cz)  
web: <http://www.poradna-prava.cz>